

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхид зохицсон газрын менежментийн бодлогоор улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 16-20 жилийн хэтийн чиглэлийн баримжаатай зураг төслийн баримт бичгийг хэлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 264 дүгээр тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г анх баталж байсан бөгөөд 2016-2018 оны хооронд шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлуулсан байна.



“Монгол улсын иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” Засгийн газрын 105 дугаар тогтоолын хэрэгжилт

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолоор улсын хэмжээнд нийт 29563 иргэнд 3583.07 га газрыг өмчлүүлэхээр баталснаас 15753 иргэнд 1954.62 га газрыг өмчлүүлсэн бөгөөд тус тогтоолын хэрэгжилт 54.6 хувьтай байна.

Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй нийт 3803 иргэнд эзэмшиж байгаа 314.21 га, 10350 иргэнд шинээр 1246.08 га, 942 иргэнд улсын чанартай зам дагуу 75.22 га, 648 иргэнд нөхөх олговортойгоор солих 318.55 га, 10 иргэнд аж ахуйн зориулалтаар үнээр нь 0.56 га газрыг тус тус өмчлүүлсэн байна. Нийслэлийн хэмжээнд нийт 2573 иргэнд эзэмшиж байгаа 180.73 га газрыг өмчлүүлсэн байна.





График. 2023 онд иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн болон өмчлүүлсэн газрын хэрэгжилт, байршлаар

Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын тухай

Улсын хэмжээнд 2024 онд нийслэл болон 20 аймгаас нийт 36624 иргэнд 4316.08 га газрыг өмчлүүлэхээр санал ирүүлснээс хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн, холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хамгаалалтын бүс, зурвас газартай давхцал, зөрчилгүй нийт 9549 иргэнд 1213.96 га газрыг өмчлүүлэхээр Засгийн газрын 2024 оны 137 дугаар тогтоолоор баталсан.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэх нийт 1211.33 га газрын 58.8 хувь буюу 428.02 га газрыг иргэдийн одоо эзэмшиж байгаа газар, 14.4 хувь буюу 273.76 га газрыг шинээр өмчлүүлэх, 26.8 хувь буюу 509.54 га газрыг нөхөх олговортойгоор солих газар тус тус эзэлж байгаа бол аж ахуйн зориулалтаар үнээр нь нийт 25 иргэнд 2.63 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн.

Үүнээс нийслэлд нийт 2884 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа 164.22 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн байна.




АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, түүний экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхид зохицсон газрын менежментийн бодлогоор аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, баримталж буй хэтийн бодлогыг газрын нөөцийн төлөвлөлтөөр дэмжин тогтвортой хөгжүүлэх 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд нийслэл болон 18 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хэрэгжиж байна.

Харин Ховд, Өвөрхангай аймгуудын төлөвлөгөөний хугацаа дууссан тул шинэчлэн боловсруулах, Хөвсгөл, Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Увс аймгууд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөндөө тодотгол хийх шаардлагатай, Говь-Алтай аймгийн төлөвлөгөө боловсруулагдаж байна.

Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан байдал



ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛСАН 18 АЙМАГ, НИЙСЛЭЛ

2024 ОНД ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ 2 АЙМАГ

2024 ОНД ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙЛГЭХ 5 АЙМАГ


ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ БАЙГАА 1 АЙМАГ

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн сумын газар, байгалийн нөхцөл, нөөц, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, орон нутгийн онцлог, уламжлалын дагуу олон төрөлт, тогтвортой газар ашиглалтыг хөгжүүлэх 5-7 жилийн хугацаанд хэрэгжүүлэх газар зохион байгуулалтын төлөвлөлтийн баримт бичиг байна.

Улсын хэмжээнд төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж байгаа 156 сум, 2024 онд төлөвлөгөө боловсруулах 105 сум, төлөвлөгөө боловсруулах шаардлагатай 69 сум байна.

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байдал



ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛСАН 156 СУМ

2024 ОНД ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ 105 СУМ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСУУЛАХ ШААРДЛАГАТАЙ 69 СУМ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЦАХИМ СИСТЕМ

“Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем” нь газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих болон төлөвлөгөөнд иргэд, олон нийтийн оролцоог хангах, хилийн цэсийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах программхангамж бүхий цогц үйл ажиллагааг юм.

цахим системд бүртгэгдсэн төлөвлөгөөний ТӨРӨЛ	үүсгэсэн төслийн тоо	БАТЛАГДСАН төслийн тоо
Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	2	1
Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	44	24
Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	1	0

цахим системд бүртгэгдсэн төлөвлөгөөний ТӨРӨЛ	үүсгэсэн төслийн тоо	БАТЛАГДСАН төслийн тоо
Нийслэлийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө	12	9
Дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	65	59
Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө	207	99
Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө	1937	1751
Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	5	0
Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	226	7
Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	43	3
Сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тодотгол	771	583
Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал	54	30
Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	4	0
Улсын тусгай хэрэгцээний газар	2	0
Хамгаалалтын бүс, зурвас газрууд	24	0
Тусгай хамгаалалттай газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө	11	1
Аймгийн төвийн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	10	3
Чөлөөт бүсийн газар зохион байгуулалт	7	4
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн кадастр	1	0
Улсын хэмжээний хамгаалалтын зурвас газрууд	1	1
Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл	14	4
Газар нутгийг УТХАГЗБ-ын улсын төлөвлөлт	1	0
Газар нутгийг УТХАГЗБ-ын аймгийн төлөвлөлт	2	0

цахим системд бүртгэгдсэн төлөвлөгөөний ТӨРӨЛ	үүсгэсэн төслийн тоо	БАТЛАГДСАН төслийн тоо
Газар нутгийг УТХАГЗБ-ын сумын төлөвлөлт	7	0
УТХАГЗБ-ын БОАЖЯ-ны нэгдсэн төлөвлөлт	1	0
Хот суурин газрын суурьшлын бүс тогтоох	1	0
НИЙТ	3453	2579